

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 06 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунгэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг Улсын Их Хурлын 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 24-ний болон 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа тус тус хэлэлцлээ.

Байнгын хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэлээр ахлуулан байгуулж, ажлын хэсэг төслийн талаар саналын томъёоллыг бэлтгэн, Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал хураалгав.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Я.Хаянхярваа хүүхдийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг онцгойлон анхаарах, хүүхэд харах үйлчилгээний стандартыг бий болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл хувийн хэвшлийн байгууллагыг хүүхэд харах үйлчилгээнд татан оролцуулах, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан хүүхэд харагчийн насны дээд хязгаарыг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын А.Тлейхан хүүхэд харах үйлчилгээний байр, хоолны стандартыг сайжруулах зэрэг саналыг гаргалаа.

Хүүхэд харах үйлчилгээг зөвхөн иргэн зохион байгуулахаар хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хуулийн төслийг дагалдан өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэж үзэж байна.


Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Нэг.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 2.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэснийг хасах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл, А.Бакей,
З.Баянсэлэнгэ, Г.Баярсайхан, С.Одонтуяа, Д.Сарангэрэл,
Д.Хаянхярваа /цаашид “Ажлын хэсэг” гэх/**

2.Төслийн 3.1.1 дэх заалтын “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт” гэснийг “5 дугаар зүйлд” гэж өөрчилж, “,хөгжүүлэх цогц” гэснийг хасах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Төслийн 3.1.2-3.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.2.“хүүхэд харагч” гэж эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэнийг;

3.1.3.“хүүхэд харах суурин үйлчилгээ” гэж хүүхэд харагч энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан орчинд гэрээт үйлчилгээ эрхлэхийг;

3.1.4.“хүүхэд харах явуулын үйлчилгээ” гэж хүүхэд харагч энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан орчинд очиж, тодорхой хугацаанд гэрээт үйлчилгээ явуулахыг;

3.1.5.”хүүхэд харах үйлчилгээний байр” гэж эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан, хүүхдийн амьдрах хэвийн нөхцөлийг хангасан бүх төрлийн орон сууц, байшин барилга, өрөө, танхимыг;”

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Төслийн 4.1.4 дэх заалтын “үйлчилгээний зохион байгуулалт нь хүүхэд харах төв” гэснийг “хүүхэд харах суурин болон явуулын үйлчилгээ нь хүүхэд харагч” гэж, 4.1.5 дахь заалтын “хүүхэд харах төв нь” гэснийг “хүүхэд харах суурин болон явуулын үйлчилгээ, орчин нөхцөл нь” гэж тус тус өөрчлөх;

Санал гаргасан: Ажлын хэсэг

5.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нас харгалзахгүйгээр хүүхэд харах үйлчилгээнд хамруулж болно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

6.Төслийн 6.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Д.Энх-Амгалан

7.Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“6.8.Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг Засгийн газар батална.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

8.Төслийн 6.5-6.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.5.Хүүхэд харагч нь бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, бага насны хүүхэдтэй харилцах арга зүй эзэмшсэн, халдварт болон сэтгэцийн өвчингүй, эрүүл, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, 18-аас 60 насны Монгол Улсын иргэн байна.

6.6.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоо 5-аас илүүгүй байх бөгөөд хүүхдийн насны ялгааг харгалзан Засгийн газар журмаар тогтооно.

6.7.Хүүхэд харах үйлчилгээний нэг байранд хамрагдах хүүхдийн тооны дээд хязгаар нь 15-аас илүүгүй байна.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

9.Төслийн 7.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.Хүүхэд харах үйлчилгээг суурин болон явуулын хэлбэрээр зохион байгуулна.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

10.Төслийн 7.3 дахь хэсгийн “12 цагаас” гэснийг “8 цагаас” гэж өөрчлөх;

Санал гаргасан: Ажлын хэсэг

11.Төслийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Эмчийн болон эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр хүүхдэд эм бэлдмэл уулгах, тариа тариулахыг хориглоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

12.Төслийн 8.5, 8.6 дахь хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.6.Хүүхдэд өдөрт 60 минутаас илүү хугацаагаар телевизор үзүүлэх, компьютер, цахим хэрэгслэлээр тоглуулахыг хориглоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

13.Төслийн 8.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.8.Хүүхэд харах үйлчилгээний байранд зөвшөөрөл авсан этгээдээс өөр гадны хүн нэвтрэхийг хориглоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

14.Төслийн 8.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.11.Хүүхэд харагч нь хүүхдэд бие махбодийн болон сэтгэл санааны аливаа хүчирхийлэл, дарамт шахалт үзүүлэх зэрэг шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

15.Төслийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.10 дахь хэсгийг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

16.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

17.Төслийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журмыг Засгийн газар баталж, жил бүрийн улсын төсөвт үндэслэн санхүүгийн дэмжлэгийг орон нутагт хуваарилна.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

18.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг хасах;

Санал гаргасан:А.Тлейхан, Л.Энх-Амгалан

19.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“9.6.Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэд харагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр төрөөс санхүүгийн дэмжлэг шаардахгүйгээр энэ хуулийн 6.1-д заасан нөхцөлийг бүрдүүлж хүүхэд харах үйлчилгээг эрхэлж болно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

20.Төслийн 10.2 дахь хэсгийн “төвийг үүсгэн байгуулах” гэснийг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

21.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.3, 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан баримт бичиг, материалыг бүрдүүлэн хүсэлт гаргасан иргэнийг сургалтад хамруулж гэрчилгээ

олгоно.

10.4.Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

22.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“11.1.8.“хүүхэд харагч нь эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан эсэхэд хяналт тавих.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

23.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

24.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.6.хүүхэд харах үйлчилгээ нь эцэг, эх, асран хамгаалагчдад нээлттэй, тэдэнд хяналт тавих нөхцлийг бүрдүүлсэн байх;”

Санал гаргасан: Ажлын хэсэг

25.Төслийн 12.1.9 дэх заалтын “сэтгэл хөдлөл” гэснийг “биеийн байдал” гэж өөрчилж, “хүүхдийн биеийн хөгжлийг хангах хөтөлбөр, дасгал хийлгэх,” гэснийг болон “хүүхдийн хөгжил, дасгал, сонирхлын талаар тэмдэглэл хөтлөх” гэснийг тус тус хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

26.Төслийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Хүүхэд харах үйлчилгээг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан иргэн зохион байгуулна.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

27.Төслийн 13.2 дахь хэсгийг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

28.Төслийн 13.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байдал, баг, хорооны Засаг даргын санал, дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

29.Төслийн 13.5 дахь хэсгийн “зөрчсөн нь” гэсний дараа “энэ хуулийн 15.2-т заасан эрх бүхий этгээдийн” гэж нэмж, “эрх бүхий байгууллагын” гэснийг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

30.Төслийн 13.6 дахь хэсгийг хасах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

31.Төслийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.3.Зөвшөөрөл авахад энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасныг нотлох материал болон баримт бичгийг бүрдүүлнэ.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

32.Төслийн 15.2 дахь хэсгийн “улсын байцаагч” гэсний дараа “, хүүхэд гэр бүлийн хөгжлийн ажилтан” гэж нэмэх;

Санал гаргасан: Ажлын хэсэг

33.Төслийн 16.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.1.зөрчил удаа дараа давтагдсан гэж үзвэл үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох;”

Санал гаргасан: Ажлын хэсэг

34.Төслийн 16.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“16.1.3.хүүхэд харах үйлчилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн бол сануулах, зөрчлийг засч залруулах, арилгах боломжтой гэж үзвэл торгох;”

Санал гаргасан: Ажлын хэсэг

35.Төслийн 17 дугаар зүйлийг бүхэлд нь хасах хасах;

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл

Хоёр.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“8.12.Эцэг, эх, асран хамгаалагч нь өөрийн хүүхэддээ хүүхэд харах үйлчилгээ үзүүлсний төлөө энэ хуульд заасан санхүүгийн дэмжлэг авахыг хориглоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Төслийн 3.1.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.2.хүүхэд харах үйлчилгээг хүүхэд харагч болон хувийн хэвшлийн байгууллага эрхэлнэ.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазар

3.Төслийн 17.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Д.Сумъяабазар, А.Тлейхан, Д.Хаянхярваа, Д.Энх-Амгалан

4.Төслийн 17.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.Энэ хуулийг 2016 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей

Гурав.Найруулгын шинжтэй санал:

1.Төслийн 6.2.5 дахь заалтын “осол, гэмтэлгүй байх” гэснийг “аюулгүй байх болон” гэж өөрчлөх.

2.Төслийн 6.3 дахь хэсгийн “төвийн” гэснийг “үйлчилгээний байрны” гэж, 6.4 дэх хэсгийн “төв” гэснийг “үйлчилгээний байр” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 7.1 дэх хэсгийн “Хүүхэд харах төвийн” гэснийг “Хүүхэд харах үйлчилгээний” гэж өөрчилж, “нээлттэй, уян хатан” гэснийг хасах.

4.Төслийн 7.3, 7.5 дахь хэсгийн “төвийн” гэснийг “үйлчилгээний”, 7.4, 7.6, 7.7 дахь хэсгийн “төв” гэснийг “үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх.

5.Төслийн 7.4 дэх хэсгийн “үдийн өмнөх, үдийн хойшхи” гэснийг “үдээс өмнө, үдээс хойш” гэж өөрчлөх.

6.Төслийн 8.6 дахь хэсгийн “төвд” гэснийг “үйлчилгээнд” гэж өөрчлөх.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн гарчгийн “санхүүжилт” гэснийг “санхүүгийн дэмжлэг” гэж өөрчлөх.

8.Төслийн 9.4, 9.5 дэх хэсгийн “төв нь” болон “төвд” гэснийг “үйлчилгээнд зориулж” гэж тус тус өөрчлөх.

9.Төслийн 11.1.2 дахь заалтыг 11.1.3 дахь заалт болгон өөрчилж, “нөхцлийн хангалтад” гэснийг “нөхцөлийг хангасан эсэхэд” гэж өөрчлөх.

10.Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Хүүхэд харах төвийн” гэснийг “Хүүхэд харагчийн” гэж, 12.1 дэх хэсгийн “хүүхэд харах төв” гэснийг “хүүхэд харагч нь” гэж, 12.1.1 дэх заалтын “хүүхэд төвд байх” гэснийг “хүүхдэд үйлчилж буй” гэж, 12.1.3 дахь заалтын “төв нь” гэснийг “үйлчилгээнд” гэж, 12.1.9 дэх заалтын “хүүхэд харах үйлчилгээний төв” гэснийг “хүүхэд харагч” гэж тус тус өөрчлөх.

11.Төслийн 13.5 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийг” гэснийг “хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг” гэж өөрчлөх.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО**